



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А1943

Улаанбаатар хот

Ачаа тээврийн цахим үйлчилгээний цахим
систем программ ашиглах тарифыг
шинэчлэн батлах тухай

Хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалт үндэслэн ТУШААХ нь:

1. Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем программ ашиглах тарифыг хавсралтаар баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Тушаал батлагдсантай холбогдуулан УБТЗ-ын даргын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/344 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.
3. Энэ тушаалыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба, ажилтнуудад тараах, зааварчилгаа өгөх, программ хангамжид зохих өөрчлөлтийг оруулах, тарифын өөрчлөлтийг www.ubtz.mn цахим хуудсанд байршуулахыг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я), Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Ц.Ариунболд), Статистик бүртгэлийн төвийн дарга (Д.Тамир), Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар) нарт даалгасугай.
4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601236248

дaргын оны
ны өдрийн
тушаалын №

Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем
программ ашиглах тариф

№	Үйлчилгээний нэр	Зочин хэрэглэгч, төгрөг/1 удаа	Гэрээт хэрэглэгч, төгрөг/1 сар
1	АТУЦС программ ашиглах төлбөр	15 000	150 000
2	Төлбөр тооцооны тайлан	5 000	50 000

№	Үйлчилгээний нэр	хэмжих нэгж	Тариф, төгрөг
1	Ачилт, ирэлтийн мэдээ	бичиг баримт, падаан	600
2	Вагоны хайлт	вагон	1 500
3	Цахим архивын үйлчилгээ	хуудас	300
